

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 7 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 3.11 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдахаас улсын төсвийн хөрөнгөөр 2.2 их наяд төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 3.126 тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламжаар 2.7 их наяд төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар 6.3 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөлд тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ц.Даваасүрэн нар хэлэлцүүлгийн явцад хууль хоорондын уялдаа холбоог хангах, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр тухайн жилийн төлөвлөгөөг зөв төлөвлөж, эдийн засгаа сэргээх, худалдааны салбарын бодлого алдагдсныг сайжруулах, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд эдийн засгаа тэлэхийн тулд гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлж, төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулах зэрэг саналыг хэлсэн болно.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баяр талархна.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ж.ГАНБААТАР